

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/36/СТА-ТӨҮГ

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| НББОУС | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ТӨҮГ | Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ХХК | Хязгаарлагдмал хувьцаат компани |

Агуулга

| | | |
|---------|---|----|
| 1 | Аудитын гэрчилгээ | 3 |
| 2 | Аудитын тайлан | 5 |
| 2.1. | Оршил | 5 |
| 2.2. | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 5 |
| 2.3. | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 6 |
| 2.4. | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 6 |
| 2.5. | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 7 |
| 2.6. | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 8 |
| 2.7. | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 8 |
| 2.8. | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 8 |
| 2.8.1 | Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл | 9 |
| 2.8.2.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал | 9 |
| 2.9. | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал . | 10 |
| 2.10. | Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 10 |
| 2.11. | Шилэн дансны мэдээлэл | 10 |
| 2.12. | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 10 |
| 2.13. | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 11 |
| 3 | Менежментийн захидал | 12 |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн тайлан | 14 |
| 4.1 | Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан | 14 |
| 4.2 | Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан | 16 |
| 4.3 | Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан | 17 |
| 4.4 | Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан | 18 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
"ЦАГААН ШОНХОР" ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.АРИУНЗАЯА ТАНАА

2019.03.15 № 06/468
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цагдаагийн Ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан санхүүгийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдалд, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын үр дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын захирал Б.Ариунзаяа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, тодруулга, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын баталсан 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан аудит хийлээ.

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг, дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 20-ноос 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Өлзийт экаунт аудит ХХК-ны аудитор Ч.Эрдэнэжав, аудиторын туслах Б.Отгонсүрэн, Ш.Бямбасүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг Өлзийт экаунт аудит ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 24 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ нь удирдах ажилтны манлайлал, ажилтан ажилчдын ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлж, ил тод шударга шуурхай хуульч ажиллагааг хэвшүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 1992 оны 05 дугаар сарын 30 өдрийн 168 тоот тушаалаар цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын дүрэмт хувцас хэрэглэл бэлтгэн нийлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа хуулийн этгээдийн алба хаагчдад зориулалтын стандарт бүхий хувцас хэрэглэлээр хангаж үйлчлэх
- Захиалагчдын захиалгын дагуу чанар стандартын шаардлага хангасан хувцас, хэрэглэлийг оёж, бэлтгэн нийлүүлэх

- Өөрийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн борлуулах нэрийн дэлгүүрийг зохих журмын дагуу ажиллуулах

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Инфосистем ХХК-ны "Макс" програм хангамж ашигладаг.

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн аудитын 20 чиглэлд эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Материаллаг байдлыг сонгохдоо нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүнгээр тооцоход дүн ойролцоо боловч үйл ажиллагааны зардлын зарцуулалтыг байгууллага өөрсдөө хийдэг тул нийт зардлыг эрсдэлтэй гэж үзэн үр дүнгийн тайлангийн зардлыг суурь үзүүлэлт болгон сонгосон.

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 511.7 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 10.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг төлөвлөлтийн үе шатанд тогтоосон 2 хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд чанарын болон орчин нөхцөлтэй холбоотой асуудал үүсээгүй болно.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 38 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 17 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 7 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Үр дүнгийн тайлангийн борлуулалт маркетингийн зардалд 12.7 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийн зардал оруулж бүртгэснийг залруулсан.
- Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг 287.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулж бүртгэсэн.
- Үр дүнгийн тайланд татвар ногдох орлогоос хасагдах зардалд 18.7 сая төгрөг бүртгэсэн байсныг залруулж татвар ногдох орлогоос хасагдахгүй зардалд бүртгэсэн.
- Тэмдэгтийн хураамж 0.4 сая төгрөг буцаж орж ирснийг бичиг хэргийн зардал бууруулж бүртгэсэн байсныг залруулсан.
- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 201.2 сая төгрөгийг үр дүнгийн тайланд тайлагнасныг залруулсан
- Мөнгөн хөрөнгөнөөс анхан шатны баримт дэмжих баримтын шаардлага хангахгүй 5.2 сая төгрөгийн гүйлгээ бүртгэснийг залруулсан.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|-------------------------|-----|-----|---------|
| 1 | Зөвлөмж өгсөн | 2 | 8.1 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 0 | 0.0 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 1 | 1.8 | |
| | Дүн | 3 | 9.9 | |

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Өмнөх оны зөвлөмжийн биелэлт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тайлант хугацаанд 8.3 сая төгрөгийн түлш шатахуун худалдан авснаас 1.9 сая төгрөгийг түлш шатахууныг тооцоо бодолгүй шууд зардалд бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын оны санхүүгийн тайлангийн аудитын явцад тус байгууллага нь төрийн өмчит үйлдвэрийн газрын статустай боловч төлөөлөн удирдах зөвлөлгүй ажиллаж байна. Мөн борлуулсан бүтээгдэхүүний өртгийг тооцохдоо үйлдвэрлэлийн процесст оролцдог ажилчдын цалинг оруулж тооцоогүйгээс өөр анхаарал татахуйц дараагийн аудитаар авч үзэхээр асуудал ажиглагдаагүй.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тайлант онд 650.0 сая төгрөгийн орлого, 638.0 сая төгрөгийн зардалтай ажиллахаар зорилтот түвшин баталж өгсөн. Тайлант онд шууд гэрээгээр 10, тендерээр 4, захиалгаар 7, бартериар 1 нийт 22 ажил авч 55.6 мянган ширхэг дүрэмт хувцас үйлдвэрлэж 704.2 сая төгрөгийн орлого олж 515.7 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны зардал борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 194.0 сая төгрөг зарцуулж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ тайлант онд эдийн засгийн зорилтот түвшинээр батлагдсан орлогыг 54.2 сая төгрөгөөр давуулж зардал 47.2 сая төгрөгөөр өссөн.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Энэхүү үүргийн хүрээнд 2018 оны 1 дүгээр сараас 12 дугаар сарыг дуустал нийт 145 мэдээ байршуулахаас 20 хоцроож 125 мэдээ хугацаандаа байршуулжээ

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 асуудалд өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 80 хувьтай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тайлант хугацаанд 8.3 сая төгрөгийн түлш шатахуун худалдан авснаас 1.9 сая төгрөгийг түлш шатахууныг тооцоо бодолгүй шууд зардалд бүртгэсэн тул албан шаардлага хүргүүлж байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт

Санхүүгийн тайланд Бээвэр ХХК-д 8.0 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байгаа боловч хаяг байршил тодорхойгүйгээс тооцоо нийлж төлж барагдуулаагүй байна.

3.1.2 Эрсдэл

Санхүүгийн тайлагналын оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байх, санхүүгийн тайлан тодруулгад тусгасан үлдэгдэл үнэн зөв баталгаажихгүй зэрэг байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан нягтлан бодох бүртгэлийн зарчмыг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт

Хувь хүнд олгосон ажил, үйлчилгээний 0.8 сая төгрөгийн зардлаас хувь хүний орлогын албан татварт 0.08 сая төгрөг суутгаагүй.

3.2.2 Эрсдэл

Хувь хүн иргэнээс бараа материал худалдан авахдаа хувь хүний орлогын албан татвар суутгаагүй шууд олгосон нь иж бүрэн байх тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д “Энэ хуулийн 11 дүгээр зүйл, 12.2, 13.1.2-13.1.4, 15.1-д заасан орлогын дүнд мөн хуулийн 23.1-д заасан хувиар, 14.1.1-д заасан орлогын дүнд 23.2.1-д заасан хувиар, 8.1.6, 8.1.7-д заасан орлогын дүнд 23.2.2-т заасан хувиар, 8.1.8-д заасан орлогын дүнд 23.2.3-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалт хэрэгжихгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль хэрэгжүүлж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | БАЛАНСЫН ЗҮЙЛ | 2017 оны 12-р сарын 31 | 2018 оны 12-р сарын 31 |
|---------------|--|------------------------|------------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 113,211,091.39 | 6,272,666.34 |
| 1.1.2 | Дансны авлага | | |
| 1.1.3 | Татвар, НДШ - ийн авлага | | 105,036.42 |
| 1.1.4 | Бусад авлага | | |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| 1.1.6 | Бараа материал | 56,706,508.99 | 80,159,877.38 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 1,500,000.00 | |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (Борлуулах бүлэг хөрөнгө) | | |
| 1.1.10 | | | |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 171,417,600.38 | 86,537,580.14 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 154,618,776.10 | 346,710,807.27 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 1,618,818.94 | 78,240,106.67 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | | |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | | |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | | |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.9 | | | |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 156,237,595.04 | 424,950,913.94 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 327,655,195.42 | 511,488,494.08 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | Өр төлбөр | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 25,534,005.00 | 30,408,883.00 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | | |
| 2.1.1.3 | Татварын өр | 8,097,767.59 | 10,050,561.78 |
| 2.1.1.4 | НДШ- ийн өглөг | | |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | | |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | | |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | | |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 125,400,000.00 | |

Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ы 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-----------------|---|-----------------------|-----------------------|
| 2.1.1.9 | Нөөц /өр төлбөр/ | | |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр | | |
| 2.1.1.12 | | | |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 159,031,772.59 | 40,459,444.78 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | | |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | | |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | | |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.5 | | | |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | - | - |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 159,031,772.59 | 40,459,444.78 |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Өмч: -төрийн | 59,469,098.00 | 59,469,098.00 |
| 2.3.2 | - хувийн | | |
| 2.3.3 | - хувьцаат | | |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | | |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | | |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | 201,226,713.00 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | 92,199,766.00 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | | 118,133,472.30 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 109,154,324.83 | |
| 2.3.10 | | | |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 168,623,422.83 | 471,029,049.30 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | 327,655,195.42 | 511,488,494.08 |

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2017 оны 12-р сарын 31 | 2018 оны 12-р сарын 31 |
|---------------|--|------------------------|------------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 624,972,180.00 | 704,239,550.00 |
| 2 | Борлуулалтын өртөг | 112,015,814.11 | 194,289,308.80 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 512,956,365.89 | 509,950,241.20 |
| 4 | Түрээсийн орлого | | |
| 5 | Хүүний орлого | 912,096.61 | 1,131,303.55 |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | 75,000.00 | 11,218,112.51 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 4,405,567.00 | 1,916,000.00 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 447,981,299.33 | 490,917,025.88 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | 18,470,778.00 | 18,842,441.21 |
| 13 | Гадаад валютын ханшын зөрүүний олз (гарз) | (3,203.62) | 11,118.19 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | | |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 43,082,614.55 | 10,635,308.36 |
| 19 | Орлогын татварын зардал | 5,966,105.62 | 2,946,662.89 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | 37,116,508.93 | 7,688,645.47 |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | | |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 37,116,508.93 | 7,688,645.47 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | | |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү | | |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| 23.3 | Бусад олз (гарз) | | |
| 24 | Орлогын нийт дүн | 37,116,508.93 | 7,688,645.47 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | 37,116,508.93 | 7,688,645.47 |

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| 1 | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|----|--|----------------------|-------------------------------------|---------------------------|-----------------------|-----------------------|
| 1 | 2017 оны 01-р сарын 01 -ний үлдэгдэл | 59,469,098.00 | | | 72,037,815.90 | 131,506,913.90 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | - |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 59,469,098.00 | - | - | 72,037,815.90 | 131,506,913.90 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | 37,116,508.93 | 37,116,508.93 |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | | | | | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | - |
| 9 | 2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 59,469,098.00 | - | - | 109,154,324.83 | 168,623,422.83 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | 201,226,713.00 | 92,199,766.00 | 1,290,502.00 | 294,716,981.00 |
| 11 | Залруулсан үлдэгдэл | | | | | - |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | 7,688,645.47 | 7,688,645.47 |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | - |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | - |
| 15 | Зарласан ногдол ашиг | | | | | - |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | - |
| 17 | 2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 59,469,098.00 | 201,226,713.00 | 92,199,766.00 | 118,133,472.30 | 471,029,049.30 |

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2017 оны 12-р сарын 31 | 2018 оны 12-р сарын 31 |
|---------------|---|------------------------|-------------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогийн дүн (+) | 758,841,021.77 | 592,473,913.00 |
| 1.1.1 | Бараа борлуулсаны, үйлчилгээ үзүүлсний орлого | 629,891,169.77 | 579,125,613.00 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 3,474,852.00 | 3,302,749.00 |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | | |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | | |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 125,475,000.00 | 10,045,551.00 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 629,863,141.05 | 695,054,759.79 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 253,441,077.68 | 301,356,291.00 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 56,316,468.35 | 69,656,860.46 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 201,661,819.78 | 225,977,748.57 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 5,428,258.75 | 8,241,058.67 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 6,734,103.00 | 10,031,478.00 |
| 1.2.6 | Хүүний төлбөрт төлсөн | | |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 37,843,406.16 | 29,867,887.70 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | | |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 68,438,007.33 | 49,923,435.39 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 128,977,880.72 | (102,580,846.79) |
| 2 | Хөрөнгө оруулалтын ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.1 | Мөнгөн орлогийн дүн (+) | 912,096.61 | 1,131,303.55 |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | |
| 2.1.6 | Хүлээн авсан хүний орлого | 912,096.61 | 1,131,303.55 |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| 2.1.8 | | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 16,950,000.00 | 5,500,000.00 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 13,800,000.00 | 5,500,000.00 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 3,150,000.00 | |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | | |
| 2.2.6 | | | |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (16,037,903.39) | (4,368,696.45) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогийн дүн (+) | 59,700,615.62 | 30,700,000.00 |

Цагдаагийн ерөнхий газрын “Цагаан шонхор” ТӨҮГ-ы 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|------------|---|-----------------------|-------------------------|
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 59,700,615.62 | 30,700,000.00 |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | | |
| 3.1.4 | | | |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 59,700,615.62 | 30,700,000.00 |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 59,700,615.62 | 30,700,000.00 |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | | |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | | |
| 3.2.5 | | | |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| 4 | Валютын ханшийн зөрүү | | 11,118.19 |
| 4.1 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 112,939,977.33 | (106,938,425.05) |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 271,114.06 | 113,211,091.39 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 113,211,091.39 | 6,272,666.34 |

4.5 Аудит хийсэн Зорилтот түвшин

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

| Д/д | Эдийн засгийн үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|-----|--|-----------------------|-----------------------|
| 1 | <u>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</u> | | |
| | б/ Үнийн дүнгээр | 650,000,000.00 | 716,600,084.25 |
| 2 | Нийт орлого | 650,000,000.00 | 716,600,084.25 |
| | Үүнээс: Цэвэр борлуулалт | 650,000,000.00 | 716,600,084.25 |
| 3 | Нийт зардал | 638,000,000.00 | 705,964,775.89 |
| | Үүнээс: Удирдлагын зардал | 638,000,000.00 | 705,964,775.89 |
| 4 | Татварын өмнөх ашиг | 12,000,000.00 | 10,635,308.36 |
| 5 | Цэвэр ашиг / алдагдал / | 10,800,000.00 | 7,688,645.47 |
| 6 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | 0.98 | |
| 7 | Нийт авлага | | 105,036.42 |
| 8 | Нийт өглөг | | 40,459,444.78 |
| | Үүнээс: Богино хугацаат өр төлбөр | | |
| 9 | Хөрөнгө оруулалт | 86,860,000.00 | 5,500,000.00 |
| 10 | Ногдол ашиг | 1,620,000.00 | 3,711,650.89 |
| 11 | Нийт ажиллагсадын тоо | 80.00 | 71.00 |
| 12 | Нийт цалингийн сан | 289,285,000.00 | 363,633,870.00 |
| 13 | Нэг ажилтны дундаж цалин | 301,300.00 | 426,800.32 |

| | |
|------------------------|--|
| Ажлын баримтын нэр: | Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл |
| Ажлын баримтын дугаар: | В501 |
| Аудитын код: | САГ-2019/36/СТА-ТӨҮГ |
| Аудитын нэр: | Цагдаагийн ерөнхий газрын "цагаан шонхор" ТӨҮГ |

| № | Аудитын чиглэл | Тоо | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Аудит хийлгэсэн байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | сая төгрөгөөр Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний | |
|------------|--|-----|---|------------|---------------------------------------|---|--|----------------------|---|--------------------------|
| | | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Зардлын данстай холбоотой асуудал | 2 | 78,7 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй | 0.078 | Зөвлөмж өгөх | | | Зөвлөмж өгөх | Захирал, нягтлан бодогч | Б.Ариунзаяа Э.Солонго |
| 2 | Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн | 2 | Жолоочийн тооцоо дутуу бодсон | 1.8 | Албан шаардлага өгөх | | | Албан шаардлага өгөх | Захирал, нягтлан бодогч | Б.Ариунзаяа Э.Солонго |
| 3 | Балансын данстай холбоотой асуудал | 2 | Бээвэр ХХК 8,006.0 олдохгүй шалтгаанаар тооцоо нийлээгүй, хэзээ, юуны өр болох нь тодорхойгүй | 8.1 | Зөвлөмж өгөх | | | Зөвлөмж өгөх | Захирал, нягтлан бодогч | Б.Ариунзаяа Э.Солонго |
| Дүн | | | | 9.9 | | | | | | |

Бэлтгэсэн:

Аудитор

Ч.Эрдэнэжав

Огноо:2019.03.13

Танилцаж, зөвшөөрсөн:

Захирал

Б.Ариунзаяа

Огноо:2019.03.13

Аудиторын туслах

Б.Отгонсүрэн

Огноо:2019.03.13

Нягтлан бодогч

Э.Солонго

Огноо:2019.03.13

|

